



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/277

Арвайхээр


### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 39 дүгээр зөвлөмжийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Спорт заалны барилга /Өвөрхангай, Төгрөг сум/ ажлыг 838120643 (найман зуун гучин найман сая нэг зуун хорин мянга зургаан зуун дөчин гурав) төгрөгөөр Сод-Ээл ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.
3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



0111006-7